

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын INC1 (Засгийн газар хоорондын хэлэлцээний хорооны анхны чуулган)-д хүргэсэн мэдэгдэлд хийсэн дүн шинжилгээ

Тодруулсан өгүүлбэрүүдийг мэдэгдлээс шилж авсан бөгөөд БОАЖЯ-ны баримталж буй байр суурь нь Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй олон байгууллага, иргэдийг нэгтгэж буй "Хогноос ангижиръя" тунхагт хэрхэн уялдаж байгааг Экосум ТББ-ын зүгээс дараах байдлаар өнгөөр ялгаж тайлбарлан дүгнэв.



"Mongolia fully supports the development of international legally binding instrument on plastic pollution" ("Монгол улс хуванцрын бохирдлыг шийдвэрлэх олон улсын хууль ёсны гэрээтэй болох санаачлагыг бүрэн дэмжиж байна")

Монгол улсын Засгийн Газар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль эрх зүйн баримт бичигтэй болохыг албан ёсоор дэмжиж буй нь тун сайшаалтай хэрэг бөгөөд энэ нь Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 16-тай яв цав нийцэж байна. БОАЖЯ тус олон улсын хэлэлцээрт идэвхтэй оролцож, Олон улсын гэрээ, баримт бичгийн агуулгыг Хогноос ангижиръя Тунхагтай уялдуулан, тууштай баримтлана гэдэгт итгэлтэй байна.



"The Constitution of Mongolia declares the citizen's right to live in a healthy and safe environment and to be protected from environmental pollution and loss of natural balance" ("Монгол улсын Үндсэн хуулинд иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, мөн орчны бохирдол, байгалийн тэнцвэр алдагдахаас хамгаалагдах эрхийг тунхагласан байдаг")

Монгол улсын иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэйг албан ёсоор олон нийтэд сануулж буй нь сайн хэрэг. Энэ нь бидний эрүүл, аюулгүй, бохирдолгүй орчинд амьдрах эрх дутуу дулимаг хууль, журам болон хувийн ашиг сонирхол гэх мэт бусад бүхий л асуудлаас дээгүүр тавигдах учиртайг баталж байна. Өөрөөр хэлбэл Засгийн Газар энэхүү эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, аливаа бохирдлоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай холбогдох хууль тогтоомжийг боловсруулж мөрдүүлэх үүрэгтэй юм. Энэ хүрээнд Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 6-д заасны дагуу Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагыг үндэсний бодлогын бичиг баримтад тусгаж үйл ажиллагаагаа явуулахдаа Үндсэн хуулиа зөрчин бохирдол үүсгэж, байгаль орчин доройтуулдаг ашгийн төлөөх томоохон корпорациудаар чанд хатуу мөрдүүлэх шийдвэр гаргах, зохих арга хэмжээг авах шаардлагатай юм.



"We set a goal to increase the amount of recycled waste to 30 percent in 2025 and 40 percent in 2030" ("Бид дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг 2025 онд 30%, 2030 онд 40% хүргэж нэмэгдүүлнэ")

Хог хаягдал байгальд тархан орчныг бохирдуулах, хөрсөнд булахаас сэргийлэх зорилгоор дахин боловсруулах хог хаягдлын хэмжээг тогтвортой өсгөх нь зүйтэй. Харин Яамнаас INC1-ийн үеэр хийсэн мэдэгдэлдээ зөвхөн хог хаягдлын дахин боловсруулалтын талаар тоон үзүүлэлтийг дурдахдаа хог хаягдлын гарцыг бууруулах, дахин ашиглах талаар огт дурдаагүй нь анхаарал татаж байна. 3R дүрэмд үндэслэн Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 8-д тусгасанаар хог хаягдлын хямралыг шийдвэрлэхийн тулд юун түрүүнд хог хаягдлын гарцыг бууруулах, түүний дараа үүссэн хог хаягдлаа дахин ашиглах, эцэст нь эхний 2 алхмыг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд дахин боловсруулах хэрэгтэй юм. Монгол Улсын Засгийн Газар энэ чухал зорилгыг дараа дараагийн хэлэлцээнд барих байр суурьтаа багтааж, хуванцар хаягдлын эсрэг тэмцэлдээ баримтлах шаардлагатай гэж үзэж байна.



"The Ministry of Environment and Tourism of Mongolia is working to create comprehensive waste management" ("Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам хог хаягдлаа зохицуулах цогц тогтолцоотой болохоор ажиллаж байна")

Яамны зүгээс хог хаягдал зохицуулах гинжин хэлхээний сегмент бүрийг салангид авч үзэлгүйгээр улсын хэмжээнд хог хаягдлаа зохицуулах цогц тогтолцоог төсөөлөн төлөвлөж байгаа нь сайшаалтай. Энэхүү цогц тогтолцоог бүрдүүлэхийн тулд Яамны зүгээс оновчтой дүгнэлт, шаардлагатай арга хэмжээг анхнаас нь авч ажиллана гэж найдаж байна. Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 7-д хог хаягдлын зохицуулалтыг цогцоор нь авч үзэхийн тулд үүнийг эрүүл мэнд, боловсролын салбарын адил олон нийт рүү чиглэсэн үйлчилгээ хэмээн харах нь чухал төдийгүй энэ тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоо тодорхой хэмжээнд шаардлагатайг ч мөн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Зөвхөн зах зээлд суурилсан арга барил хог хаягдлын зохистой зохицуулалтыг цогцоор нь хэрэгжүүлэхэд хангалтгүй бөгөөд чанд хатуу бодлого боловсруулж системтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай юм.



"[The Ministry of Environment and Tourism of Mongolia is working to] increase waste recycling" ("Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам хог хаягдлын дахин боловсруулалтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна")

Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 9-д зааснаар юун түрүүнд хог хаягдлын гарцыг бууруулах, дахин ашиглахад анхаарч, дахин боловсруулалтыг цогц, ерөнхий төлөвлөгөөнийхөө зөвхөн нэг хэсэг болгон тусгавал үр дүнтэй болж чадна. Цаашлаад Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 10-д заасны дагуу Яамны зүгээс үр дүнтэй дахин боловсруулалт болон зэрэг бууруулж боловсруулах (өмнөхөөсөө чанар муу бүтээгдэхүүн гаргах) хоорондын ялгааг тодорхой болгож, үүнийг холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай. Жинхэнэ дахин боловсруулалт нь тойрог эдийн засгийг дэмждэг бол зэрэг бууруулж боловсруулах нь үйлдвэрлэл – хэрэглээ – хаягдал гэсэн шугаман эдийн засагт завсрын үе шат болж нэмэгддэг. Иймд, БОАЖЯ бодит дахин боловсруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, одоогоор зэрэг бууруулсан боловсруулалт хийж байгаа салбаруудыг үр дүнтэй дахин боловсруулалтад шилжүүлэх талаар ажиллах нь зөв болов уу.



"[The Ministry of Environment and Tourism of Mongolia is working to] introduce waste-to-energy technologies" ("Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хогноос эрчим хүч гаргаж авах технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байна")

Энэ бол БОАЖЯ-ны ТНБД-ын хийсэн мэдэгдлийн хамгийн анхаарал татсан, асуудал дагуулах хэсэг юм. Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 11-д тайлбарласаны дагуу хог хаягдлыг шатаах, тэр дундаа хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх үйл явц нь шийдэл болохоосоо илүүтэй олон асуудал дагуулдаг болох нь шинжлэх ухааны үндэслэлтэй нотлогдсон байдаг. Хог хаягдлыг шатаах явц нь хүний эрүүл мэндэд асар хортой бодисууд ялгаруулж, байгаль экологи, уур амьсгалд аймшигтай сөрөг нөлөөллийг үзүүлдэг. Хог шатаах нь хог хаягдлын гарцыг бууруулахад садаа болоод зогсохгүй (шатаах үйлдвэрүүд ашигтай ажиллахын тулд их хэмжээний хог шатаах шаардлагатай болдог) дахин боловсруулах салбартай өрсөлддөг (хуванцар сайн шатдаг учир шатаах үйлдвэрүүд ангилан ялгаагүй, дахин боловсруулах боломжтой их хэмжээний хуванцар шатаадаг). Хогноос эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэл нь анхны хөрөнгө оруулалт болон урсгал зардлын хувьд асар өндөр өртөгтэй хэрнээ эрчим хүч үйлдвэрлэх хамгийн үр дүнгүй арга юм. Иймээс хог шатаах технологийг Монгол улсад огт нэвтрүүлж болохгүй. Тиймээс Яамны зүгээс үүнийг эргэн харж бусад боломжит шийдэл, хувилбаруудыг тооцох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.



"We have to implement measures that are based on the national circumstances of each country"

("Бид улс орон бүрийн онцлогт тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай")

Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 5-д дурьдсаны дагуу хог хаягдлыг зохицуулах төлөвлөгөөндөө үндэсний онцлог, нөхцөл байдлыг тусгах нь чухал бөгөөд бусад улс орнуудын дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэхэд хэт их ач холбогдол өгч, гадны хог хаягдал зохицуулах тогтолцоог сохроор даган дуурайхгүй байхад анхаарах нь зүйтэй юм. Хог хаягдлыг багасгаж бууруулах, үр дүнтэйгээр дахин ашиглах болон дахин боловсруулахад шаардлагатай дүрэм журам боловсруулж, хог хаягдлаа зохистой зохицуулахад өнөөгийн Монгол улсад ашиглагдаж болохуйц технологиудыг нэвтрүүлж, хэрэгжүүлвэл үр дүнгээ өгнө.



"We fully support the idea that the international legally binding instrument should cover the whole life cycle of plastics in a manner that promotes resource efficiency and a circular economy"

("Хуванцрын амьдралын мөчлөгийг бүхэлд хамруулж нөөцийн үр дүнтэй ашиглалт, тойрог эдийн засгийг дэмжсэн олон улсын хууль эрх зүйн бичиг баримттай болох санаачлагыг бид бүрэн дүүрэн дэмжиж байна")

БОАЖЯ-ны мэдэгдэл мөн Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 1, 6-д дурдсанаар энэхүү олон улсын баримт бичиг, цаашлаад Монгол улсын хууль тогтоомж, бодлогын бичиг баримтуудад хуванцрын амьдралын мөчлөгийнх нь эцсийн шатанд буюу хог хаягдал болсон үед л (дахин ашиглах, дахин боловсруулах, дарж булшлах) төвлөрөх бус амьдралын мөчлөгийг нь бүхэлд нь тусгаж, байгалийн нөөцийг хэмнэх, тойрог эдийн засгийг дэмжихэд анхаарах шаардлагатай юм. Хуванцрын амьдралын мөчлөгийг бүхэлд нь авч үзэхэд нэг л дүгнэлтэд хүрдэг: Хуванцар нь хог хаягдлын хувьд зохицуулахад ярвигтай төрөл төдийгүй түүхий эдийг нь олборлож эхлэх мөчөөс л үй олон асуудал ар араасаа үүсдэг. Тиймээс л холбогдох бодлогын бичиг баримтуудаа хуванцар материал хаягдах шатанд бус хуванцрын үйлдвэрлэл, хэрэглээнд ч мөн чиглүүлэх шаардлагатай бөгөөд юун түрүүнд хуванцрын хэрэглээг журамлаж зохицуулах, улмаар бууруулах, жишээлбэл, нэг удаагийн хуванцрын хэрэглээг хориглох (Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 14), сав баглаа боодлыг стандартчилах (Хогноос ангижиръя Тунхгийн Зарчим 15) замаар тойрог эдийн засгийг жинхэнэ утгаар бэхжүүлэхэд чиглэх ёстой юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газар энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээнд оролцож байгаа нь сайшаалтай хэрэг бөгөөд INC1-н үеэр хийсэн Яамны мэдэгдэлд нүдээ олсон зорилго, байр сууриа ч тусгасан байна.

Харин уг мэдэгдлийн зарим хэсэг анхаарал татаж байгаагаас тодруулбал, мэдэгдэлд байгаль орчныг хамгаалах, хог хаягдал зохицуулах цогц тогтолцоог бий болгох, хуванцрын амьдралын мөчлөгийн бүхэлд нь авч үзэхийг дэмжих гэсэн ерөнхий үзэл санааг илэрхийсэн боловч чухам ямар арга хэмжээ авахыг тусгаагүй, тодорхой зорилго дэвшүүлээгүй байна.

БОАЖЯ дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх талаар тоон үзүүлэлт бүхий зорилт тавьсан боловч мэдэгдэлдээ хамгийн чухал алхамууд болох "бууруулах", "дахин ашиглах" талаар огт дурдаагүй байна. Түүнчлэн нэг удаагийн хуванцрыг хориглох, сав баглаа боодлын стандартчилал, үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага гэх мэт нэн тэргүүний арга хэмжээнүүдийн талаарх бодлого, хэрэгжилтийн асуудал огт хөндөгдөөгүй байна. Цаашилбал, хамгийн санаа зовоосон асуудал нь хог хаягдлаас эрчим хүч гаргах технологийг Монгол



Улсад нэвтрүүлэхэд бэлэн байгаагаа Яамны зүгээс илэрхийлсэн явдал юм. Энэ төрлийн технологи нь сөрөг үр дагавартай, бүр үр ашиггүй болох нь олон судалгаагаар нотлогдсон тул дэлхий дахинд үүнийг зөвлөхөө болиод байгаа.

Дүгнэж хэлэхэд, Монгол Улсын Засгийн газар хог хаягдлын талаарх үндэсний хэмжээний зорилт, хөтөлбөрөө эргэн харах нь зүйтэй байна. БАОЖЯ хог хаягдлын хямралыг шийдвэрлэх бодлого боловсруулахдаа “Хогноос ангижиръя” Тунхгийн зарчмуудыг тусгах нь чухал бөгөөд INC2-н үеэр Монгол улсын Замгийн газраас хийх дараагийн мэдэгдэлд бидний дүн шинжилгээ, ажил хэрэгч шүүмжлэл тусгалаа олно гэж найдаж байна.

**STATEMENT BY STATE SECRETARY OF THE MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM OF MONGOLIA
H.E. MR. BATTULGA ERKHEMBAYAR**

**1ST SESSION OF THE INTERGOVERNMENTAL NEGOTIATING COMMITTEE
TO DEVELOP AN INTERNATIONAL LEGALLY BINDING INSTRUMENT ON
PLASTIC POLLUTION, INCLUDING IN THE MARINE ENVIRONMENT**

Excellencies,
Distinguished delegates,

Mr. Chairman, first of all, I would like to congratulate you for being elected as chair of INC. We look forward to your able leadership.

Our delegation greatly appreciates the Government of Uruguay for hosting this meeting and we all enjoy staying in beautiful city of Punta del Este.

We also very grateful to the UNEP Secretariat for successful organization of this INC-1 meeting.

Mongolia fully supports the development of international legally binding instrument on plastic pollution, including the marine environment.

The Constitution of Mongolia declares the citizen's right to live in a healthy and safe environment and to be protected from environmental pollution and loss of natural balance. In this regard, we set a goal to increase the amount of recycled waste to 30 percent in 2025 and 40 percent in 2030 in the Vision-2050 long-term development policy.

The Ministry of Environment and Tourism of Mongolia is working to create comprehensive waste management, increase waste recycling, and introduce waste-to-energy technologies. The total amount of solid waste in Mongolia reached 2.8 million tons in 2021, which is a 5.5 percent decrease from 2020.

We have to implement measures that are based on the national circumstances of each country. And we fully support the idea that the international legally binding instrument should cover the whole life cycle of plastics in a manner that promotes resource efficiency and a circular economy.

I would like to emphasize the importance of fostering innovation, encouraging actions by all stakeholders including the private sector, and promoting cooperation at the global, regional, national, and local levels.

Thank you for your attention. I wish you a successful session.